



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 356

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Булган АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1. Зам, тээврийн хөгжлийн сайдын ирүүлсэн саналыг үндэслэн Базарсадын Батсайханыг "Булган АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалаас 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу дуусгавар болгох;

1.2. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/2572 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2018 оны 05/5736 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан Батсуурийн Ууганбаярыг "Булган АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар томилж, контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА